

жээ. Ийнхүү Монгол улсын түүх, Богд хааны амьдрал, үйл ажилд чанарын шинэ үе эхэлжээ.

Богд хаант улсын гадаад бодлогын ерөнхий чиг баримтлал ардын засгийн үед ч уламжлагдан шинэ агууллагаар баяжин хөгжсөнийг эцэст нь тэмдэглэж хэлье.

ӨВӨР МОНГОЛ ДАХЬ МОНГОЛ ТҮҮХ СУДЛАЛЫН ТОЙМ

Хэрээд. Л. Жамсран*

Монгол, Хятад хоёр улсын харилцаа хэвийн болж, тус бүрдээ нээлттэй бодлого явуулсны ачаар хоёр орны хамтын ажиллагаа шинэ хэлбэрүүдээр хөгжин гүнзгийрч бүхийд ШУА-ийн Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн ажилтан бид хоёр хүн Өвөр Монголын Их Сургуулийн монголын ойр ба орчин үеийн түүх судлах тэгш солилцооны газарт тэгш солилцооны эрдэм шинжилгээний томилолтоор 1992 оны сүүлчээр очиж цөөн хоног ажиллав. Тэгэхэд мэргэжил нэгт Өвөр Монгол нөхөд биднийг номын санд ажиллах түүхийн дурсгалт газраар тойрон аялах зэрэгт ах дүүгийн халуун сэтгэлээр туслаж байлаа. Өмнөт Монгол буюу Өвөр Монгол нь зөөлөн уур амьсгалтай тул дээр үеэс мал аж ахуйн зэрэгцээгээр тариалан түлхүү эрхлэн суурьшиж эхлэсэн бөгөөд хүн амын тоогоор ч монгол угсаатны олонхи билээ. Шарын шашин Өвөр Монголд эхлэн дэлгэрч улмаар монголын бусад хэсэгт дэлгэрсэн, Монголын бичгийн мэргэд эрх чөлөөний төлөө тэмцэгчид мөн энэ нутгаас цөөнгүй төрсөн. Түүхийн таагүй нөхцөлд эх хэл, бичиг, түүх соёлоо нандигнан хамгаалж хадгалж ирсэн Өвөр монголчууд өөрчлөлт шинэчлэлийн одоо үед аж амьдралаа үзэгдэхүйц сайжруулж эдийн засаг, соёлын талаар чамгүй амжилт олж буйг нүдээрээ үзэв. Хэдүй тийм боловч тэр бүхнийг үл өгүүлэн харин өөрийн уншсан, мэргэжил нэгт нөхдөөс сурвалжилж мэдсэнээ үндэслэн Өвөр Монгол дахь өөрчлөлт шинэчлэлийн нэг хэсгийг энэхүү өгүүлэлд тойм төдий бичиж уншигч олондоо толилуулая.

Нэг. Монгол түүх судлалын гол байгууллагууд

Монголчууд эх түүхээ судлаж бүтээл туурвиж ирсэн уламжлалтай. Түүнд Өвөр Монголчууд чухал суурь эзлэдэг боловч үндэсний ардчилсан хувьсгал ялж Өвөр Монголын өөртөө засах орон (ӨМӨЗО) байгуулагдсан түүхийн шинэ нөхцөлд Монгол түүхээ тусгайлан судлах ажил 50-аад оны үеэс эхлэсэн агаад 1958 онд Өвөр Монголын түүх судлах газар (институт), олон нийтийн эрдэм шинжилгээний байгууллага «Өвөр Монголын түүхийн нийгэмлэг» байгуулагдаж монгол түүхээ судлах ажил эрхлэх болсон юм. Мөн оноос Өвөр Монголын Их сургууль, Өвөр Монголын багшийн дээд сургуульд монгол түүх судлах тасаг байгуулагдан ажиллаж эхлэсэн боловч БНХАУ-д болж байсан улс төр, үзэл суртлын давалгаа хийгээд төрийн үндэстний бодлогын хатууралт зөөлрөлтийн улмаас буураад дахин өрнөж байгаа ажээ. «Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан» сэтгүүлийн 1987 оны 4 дүгээрт: «...хэт зүүний хэлбэрэл нь мөн манай орны монгол түүх судлалд нөлөөлсөөр

*Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, дэд доктор

билээ. Ялангуяа арван жилийн дотоодын самууралын (соёлын хувьсгалын Л. Ж.) үед манай орны монгол түүх судлал бараг зогсонгуй байдалд оржээ» гээд сүүлийн үед Өвөр Монголд монгол түүх судлал амжилттай хөгжиж байгааг бичсэн бий. Одоо ӨМӨЗО-д монгол түүх судлалын ажлыг дараахь газрууд дагнан хийж байна. Үүнд:

1. Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэн (академи) -д профессор Лю Цзинсо захиралтай, эртний ба дундад эртний түүхийг голлон судалдаг судлах газар.

2. Өвөр Монголын их сургуульд монгол түүх судлах газар хоёр байна. Үүнд профессор Буянхүү захиралтай, эртний ба дундад эртний түүх судалдаг, профессор Отгонбилэг (Хоу Вэймин) захиралтай ойр ба орчин үеийн түүх судладаг.

3. Өвөр Монголын багшийн их сургуульд феодалын бутрал, Манжийн үеийг судалдаг судлах газар бий. Түүнийг профессор Алтан-Оргил (Цзинь Фэнь) толгойлж байна.

4. Их зуу аймагт 1987 оноос Чингис судлалын нийгэмлэг ажиллаж «Чингис судлал» гэдэг сэтгүүл гаргаж байна. Бас Чингис хааны онгоны дэргэд Шаралдай захиралтай Чингис хааныг судлах газар ажиллаж байна. Бас Жирэм аймгийн Тунляо хот дахь Монгол үндэстний багшийн дээд сургуульд монгол түүхийн заах судлах тасаг (тинхэм) байдаг ажээ. Монгол түүх судалдаг газар ийнхүү олшрохын хамт эрдэм шинжилгээний хэвлэл бас олширсон. 1958 онд тус орны нийгмийн ухааны анхны сэтгүүл «Монгол хэл, түүх утга зохиол» сэтгүүл хэвлэгдэн гарсан. Дараа нь «Өвөр монголын их сургууль» (1985 онд), «Өвөр Монголын багшийн их сургууль» (1985) «Өвөр монголын нийгмийн шинжлэх ухаан» (1985), «Өвөр монголын үндэстний багшийн дээд сургууль» (1985) зэрэг эрдэм шинжилгээний чухал сэтгүүлүүд монгол, Хятад хэлээр хэвлэгдэн гарч монгол түүх судлалын ололтыг сурталчилдаг өргөн индэр болж байна.

Шинжлэх ухааны хүрээлэн, их сургуулиудын монгол түүх судлах газар, заах судлах тинхэмээс гадна өөртөө засах орны нам, төр, олон нийтийн байгууллага бүхэн өөрсдийнхөө зардлаар өөрсдийнхөө түүхийг судлах сурталчлах төсөл боловсруулан сонирхолтой ажил зохиодог юм байна.

Нам олон нийтийн байгууллага өөрсдийн түүхийн материал цуглуулах, цэгцлэх ахмад зүтгэлтнүүдийг сурвалжлах дуртгал бичүүлэх зэрэг ажил хийж байхад ӨЗО-ны засгийн газраас төв орон нутгийн ойлборыг 80-аад оны дунд үеэс эхлэн бичүүлж байгаа ажээ. Тийн ойлборыг хэрхэн бичих сурах бичиг, аргачилсан лавлах зэргийг хэвлэн нийтлэж нийтийн хүртээл болгосон агаад орон нутгийн ойлборт газар зүй, улс төр, эдийн засаг, соёл эрүүлийг хамгаалахын өнөөгийн байдлыг голлон бичиж өнгөрсөн түүхийг бага дурддаг ажээ. Тийнхүү ойлбор бичихэд ашиглаж болохуйц бүх сурвалжийг түшиглэдэг, зохиогчид нь заавал тусгай мэргэжсэн нийгэм судлагчид байдаггүй харин тухайн аймаг, хот, хошуу, сянь болон албан байгууллагын ажил амьдралыг сайн мэдэх хүмүүс байдаг. Энэ бол «Мандаж байгаа төр ойллогоо бичдэг» уламжлалын дагуу шинэ агуулга хэлбэрээр хийгдэж буй, аль ч улс оронд хийж болох сонирхолтой ажил. Аймаг, хот, хошуу, сянь бүрийн улс төрийн зөвлөлгөөний соёл түүхийн комисс үүнийг хариуцан хийлгэдэг. Жишээ нь: Өвөр Монголын улс төрийн зөвлөлгөөний түүхийн материал судлах гишүүдийн хурлаас эрхлэн 70-аад оны сүүлчээс «Өвөр Монголын түүхийн материал» гэдэг 30-аад эмхтгэл монголоор хэвлэн гаргажээ. Мөн өөртөө засах орны засгийн газраас эрхлэн мон-

гол сурвалж бичгийг «Монгол тулгар бичиг», «Монголын судлалын орчуулга», «Монгол аман зохиол» гэдэг гурван төрлийн цувралаар 1983 1984 оноос эхлэн хэвлэж байна.

1979 онд Хөх хотод «Монголын түүх судлах бүх Хятадын нийгэмлэг» байгуулагдсан. Түүний төв нь Өвөр Монголын Их сургууль дээр байдаг бөгөөд Монгол түүх судлал» гэдэг сэтгүүл 4-ийг гаргаад байна. БНХАУ-ын олон газар Монгол түүхийн холбогдол бүхий 10 гаруй судлах газарт 200 шахам хүн ажиллаж байгаа гэнэ. ӨМӨЗО-өөс гадна тус улсын бусад муж, өөртөө засах оронд түүхийн янз бүрийн үед цацагдан суурьшсан эсвэл суугуул нутгаараа харъяалагдах болсон Монгол үндэстний тойрог, хошуу, сяньд цөмд нь орон нутгийн түүхээ судлах байгууллага болох түүх тэмдэглэлийн албан гэр ажиллаж нутаг орныхоо түүх соёлын тэмдэглэлийг бэлтгэж хэвлүүлдэг амуй. ӨМӨЗО ны түүхчид зөвхөн өөрийн оронд төдийгүй БНХАУ-ын хэмжээний монгол түүх судлалын ажилд идэвхтэй оролцож байна. Тухайлбал, 1980 онд бий болсон «ЮАН УЛСЫН ТҮҮХ СУДЛАХ НИЙГЭМ-ЛЭГ» Синь цзян-Уйгурын өөртөө засах орноос эрхлэн 1989 онд байгуулсан «Ойрадын түүх судлах нийгэмлэг» -ийн ажилд оролцож бүтээл туурвилаа нийтийн хүртээл болгож байна.

Хоёр. Монгол түүх судлалын бүтээлийн тойм

Өвөр Монголын хуучны судлалтан (археологич) түүхч нар нэн эрт цагаас одоо хүртэлх үеийн монголын түүхийг шаргуу судлаж, харьцангуй ахар хугацаанд олон бүтээл гаргажээ. ӨМӨЗО-ны хуучныг судлах газрын ажилтнууд олон газар малтлага шинжилгээ хийж анхны хүй нэгдлийн үеэс тус нутаг оронд хүмүүс амьдран сууж байсны ул мөр, түүхийн янз бүрийн үед холбогдох эд өлгийн дурсгалуудыг нээж илрүүлсээр байна. Түүхчид монгол үндэстний эрт өдгөөгийн түүхийг тал бүрээс нь судлаж хийсэн туурвилын тоймыг дараахь хэдэн зүйлээр ангилж танилцуулъя.

1. Ерөнхий түүхийн зохиол гэвэл Лю Цзинсо, монголын хураангуй түүх (1985 онд) Буянбат, Монголын бөөгийн шашны учир, Монгол үндэстний товч түүх (1987) Ү. Байчүнь, Со Чжү Монголын хаант улсын товч түүх (1990) Дай Хүни, Б. Буян, Умарт Юан улсын түүх (1991) Тайчуудай Мансан, Монгол бөө мөргөл (1990) гэх зэрэг. Тэрчлэн Монголын хаадын тухай олон ном гарчээ. Тэдгээрийн заримыг дурдвас: Н. Алтаншаа, Монголын гурван хаан-Өгөдэй, Гүюг, Мөнх (1985) Сайшаал, Чингис хааны товчоон, 2 боть (1987); Г. Намжил Чингис хааны засаг ба билэг. (1989); Доронатив, Чингис хааны цэргийн эрдэм (1990); Хүн Чжүбин, Чжан Цзэфан, Хубилай хийгээд Юань улс (1987); Намсрай, Галдан бошогт (1987); Одон, Эсэн хаан (1988); Монгол үндэстний орчин үеийн цуут хүмүүс (1990); Чийрэгхүү, Жибзундамба хутагтын товч намтар (1992) гэх зэрэг номууд монголоор хэвлэгдэн гарчээ. Эдгээрээс гадна Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн түүх судлах газраас зохиосон «Монгол үндэстний нэвтэрхий түүх» 3 боть (1991), Их зуу аймгийн монгол үндэстний нэвтэрхий түүх найруулах газраас нийтлүүлсэн «Монгол үндэстний нэвтэрхий түүх» гуравдугаар боть (1991), ӨМИС-ийн профессор Хоу Вэймин (Отгонби лэг) найруулсан «Өвөр Монголын Ойр үеийн товч түүх» (1990), «Өвөр монголын өөртөө засах орны түүх» (1991), Тогтох, «Эсгий туургатны мандалт бууралт-Хүннүгийн бүлэг» (1987), Лин Ган «Түрэгүүдийн түүх» гэх мэт нэвтэрхий (ерөнхий түүхийн болон аль нэгэн үеийг судласан зохиолууд хятад хэлээр гарчээ.

2. Орон нутгийнхаа түүхийг судлаж бичих ажил бас шаргуу хийгдэж байна. Түвшинням. Баргачуудын түүхэн ирэлт (1985), Цахар Монгол (1989), С. Наран, Ордосын ардын дугуйлангийн хөдөлгөөн (1989), Чинначин, Хуучид аймгийн түүхэн тойм (1990), Боржигдай Оюунбилэг, Хошууд товчоон (1990) зэрэг эрдэм шинжилгээний бүтээлүүдээс гадна аймаг хошуудын соёл түүхийн материалын олон эмхтгэл эх хэлээрээ хэвлэгдэн гарч байна. Жишээ нь: 80-аад оны сүүлчийн хагаст Алашаа, Ихзуу, Баяннуур, Улаанцав аймаг тус бүр 3 эмхтгэл. Шилийн гол аймаг 5 эмхтгэл хэвлүүлжээ.

Тулгар (сурвалж бичиг зохиолыг хэвлэж нийтийн хүртээл болгох талаар их ажил хийж байна. Үүнд: Эрдэнийн товч (1980). Профессор Баяр, Монголын нууц товчоог зохиогч, галиглагч орчуулагч нарын тухай судалгаа, хятад галиг, орчуулга, олон улсын галиг. Эрт өдгөөгийн монгол эх, авианы толины хамт гурван ботиор (1981), Арван буянт номын цагаан түүх (1981), Гангын урсгал (1981), Монгол зан аалийн ойлбор (1981), Уйгуржин монгол үсгийн дурсгалт бичгүүд (1983), Ойра дын түүхэн сурвалж бичиг (1985), Ойрад цааз (1985), Тайчуудай мансан. Шинээр орчуулж тайлбарласан монголын нууц товчоо (1985). Элдэнтэй Ардаажав Монголын нууц товчоо-сийрүүлэл, тайлбар (1986), профессор Ихмянгадай Иринчин, Монголын нууц товчооны сэргээлт (1987), Дай Юан улсын түүх (1987). Дай Ляо улсын түүх (1987), Хөх хотын түүхэн монгол сурвалж бичиг 6 боть (1986—1990). Хаадын үндсэн хураангуй Алтан товч (1989), Монгол боржигд овгийн түүх (1989), Халх журам (1989). Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг 2 боть (1989) гэх зэрэг олон тулгар бичгийг монголоор гаргаснаас гадна «Монголын нууц товчоо» (1981), Алтан товч (1985), Эрдэнийн товч зэргийг хятадаар хэвлүүлжээ.

4. Монгол түүх судлал бол БНХАУ-д сүүлийн үед их анхааран хөгжүүлж буй монгол судлалын чухал хэсэг юм. Иймээс Өвөр Монголын Хэвлэлийн хороот тухайлбал, Хөх хот дахь ӨМ-ын Ардын Хэвлэлийн Хороо, ӨМ-ын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, Хайлаар дахь ӨМ-ын соёлын хэвлэлийн хороо, Монгол түүх, судлалаар манай улсад гарсан зарим бүтээлүүдийг монгол бичгээр хөрвүүлэн хэвлэж байна. Үүнд БНМАУ-ын түүх гурван ботийг зургаан ботиор (1986 онд) БНМАУ-ын угсаатны зүй (1990), БНМАУ-ын соёлын түүх (1988) гэх мэт. Бас хятад болон гадаад хэлээр гарсан нэлээд бүтээлийг монголоор орчуулан хэвлүүлж Монгол уншигчдын хүртээл болгожээ. Лу Минхүй Монголын «Өөртөө засах хөдөлгөөний» үүсэл, төгсгөл (1986), Чжан Му, Монгол хошуу нутгийн тэмдэглэл, гурван боть (1988), Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл зэрэг урьд өдгөөгийн хэдэн бүтээлийг монголоор гаргажээ. Өвөр Монгол нөхөд Монголын тухай Хятадын олон төрийн албан түүх ба хувь хүмүүсийн тэмдэглэл зэрэг арвин сурвалжийг Монголоор орчуулан энэ мэт хэвлэж байх юм бол зөвхөн монгол уншигчид төдийгүй олон улсын монгол түүх судлалд их тус болохсон билээ.

XIII зууны үед Их Монгол улсад ирж байсан Плано Карпани, Вильгельм Рубрик, Марко Поло нарын аян замын тэмдэглэлүүдийг 80-аад онд Монголоор орчуулан хэвлэжээ. Доссон, Монголын түүх (1988). Жувэйни, Дэлхийг байлдан дагуулагчдын туух хоёр боть (1988) болон японоос Чингис хаан, Хубилай хаан (1987) Чингийн үе дэх монголчуудын нийгмийн байгуулал (1988). Оросоос Монгол-Татар Ази Европод (1989), Монгол ба Тангут (1990), Германаас Монголын түүх ба соёл

(1986) гэх зэргийн олон зохиолыг гадаад хэлнүүдээс орчуулж монголоор хэвлэжээ.

ӨМӨЗО-нд сүүлийн жилүүдэд хэвлэсэн монгол түүх судлалын бүтээлийг товч тоймлоход ийм байна.

Өвөр Монголын эрдэмтэд ойрын ирээдүйд Өвөр Монголын ойллого, Өвөр Монголын үндэстний ойллого, Өвөр Монголын нэвтэрхий түүхийг олон ботиор гаргахаар шамдан ажиллаж байна. Өвөр монголчууд бол БНХАУ-ын цөөн тоот үндэстний нэг төдийгүй суугуул нутагтаа бас хүн амын цөөнх тул монгол түүх судлалын гол бүтээлүүдээ юуны урьд тус улсын олон үндэстний харилцааны нийтлэг хэрэглүүр болж байгаа хятад хэлээр хэвлүүлж, үндэстнээ хэрхэн мэдэрч, түүхээ яаж судлаж байгаагаа хятад болон бусад үндэстнүүддээ мэдүүлэхийг урьдал болгодог тул бараг бүх бүтээл нь хятад монгол хаёр хэлээр нийтлэгддэг бололтой. Өвөр Монгол бол бүх монгол үндэстэн биш түүний зөвхөн нэг томхон хэсэг нь билээ. Иймд эх түүхийнхээ судлалаар тэдний олсон ололт нь тухайн улс орны үндэстний бодлого, эрдэмтэдийн идэвх зүтгэлээр тодорхойлогдох бөгөөд Монгол улс, Оросын холбооны улс дахь Монгол угсааны улсуудад нэгийг бодогдуулах нь мэдээж. Монгол түүх судлал зөвхөн уг үндэстэн, угсааны улс, орон төдийгүй олон улсын судлагдахуун болсон өнөө үед судалгаанд нэг загварын хэвшмэл үзэл бодлыг ягшихгүй олон ургалт үзлийг уралдуулан харилцан ойлголцож, хамтран ажиллавал нэн их амжилтад хүрэх нь дамжиггүй.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Б. Б. БАРАДИН (1878—1937)

С. А. Максанов

Базар Барадиевич Барадин Агын буриад Барадий Боронжоевын гэрт төрсөн бөгөөд түүний 11 хүүхдийн ууган нь юм. Түүний эцэг нь тухайн үедээ боловсролтой хүн байв.

Базар Агын дөрвөн ангитай сургуулийг дүүргээд Чит хотын гурван ангитай сургуульд орж суралцсан боловч төгсгөлгүй 1895 онд Петербурgt очиж П. Бадмаевын гимназид суралцаж байгаад 1900 онд нутагтаа буцаж иржээ.

1902 онд Жамсрангийн Цэвээнтэй хамт Петербургийн Их сургуулийн дорно дахины хэлний салбарт орсон. 1908—1917 онд Барадин их сургуульдаа монгол хэлний багшаар ажиллаж профессор цол хүртсэн.

Тэр их сургуульд орохоосоо өмнө Герман, Итали, Швейцариар аялж, өрнөдийн хэлүүд судалж байв. Их сургуульд суралцаж байхдаа ч гэсэн Европын орнуудаар явж, англи, герман, франц хэлийг эзэмшсэн. Их сургууль төгссөнийхөө дараа Төвдөөр аялж буддизмын тухай судалгааны хэдэн өгүүлэл бичсэн.

Б. Барадин 1905—1907 оны хувьсгалын жилүүдэд оюутан байхдаа нийгэм улс төрийн үйл ажиллагаагаа эхэлж буриадын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд оролцсон. Буриадын анхдугаар их хурлын ажлын үед буриадад үндэсний өөрийн захиргааг бий болгох, буриадын соёлыг хөгжүүлэхийн төлөө идэвхтэй тэмцэж байв. Б. Барадин бол шарын шашныг шинэчлэх хөдөлгөөнийг үүсгэгч, үзэл сурталчдын нэгэн билээ. Бүр 1905 онд тэрээр Жамсрангийн Цэвээнтэй хамтран Виттед лам нарыг буддынхан гэж өөрчлөн нэрлэх хүсэлт тавьж